



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ 2024



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ - 2024

Улаанбаатар хот
2025 он

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, Энхтайван найрамдлын ордон

Утас: 260182

Э-шуудан: info@mmra.gov.mn

Вэб сайт: www.mmra.gov.mn

SCAN ME!



Эрхэлсэн:

Н.Эрдэнэбаяр

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын дарга

Хянасан:

Б.Одгэрэл

ЭЭХХЗГ-ын Захиргаа, удирдлагын
газрын дарга

Эмхэтгэсэн:

М.Одонтуяа

ЭЭХХЗГ-ын Захиргаа, удирдлагын мэргэжилтэн

Мэдээлэл бэлтгэсэн:

Л.Батзориг
Д.Оюун-эрдэнэ
Э.Одбаяр
Б.Санж-Очир
Д.Алимаа
М.Шинэцэцэг
Б.Соёлчимэг
М.Тэгшсайхан
Б.Хатантуул

ЭЭХХЗГ-ын ЗУГ-ын ахлах мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын ахлах мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЭҮХ-ийн ахлах мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЭТТГ-ын мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЧХГ-ын улсын байцаагч
ЭЭХХЗГ-ын ЛЗЗГ-ын мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЭАБТСГ-ын мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЭБХ-ийн мэргэжилтэн
ЭЭХХЗГ-ын ЭШЛ-ийн ахлах шинжээч



АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
1. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ	5
1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	8
1.2.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан	8
1.2.2. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан	9
2. ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ	10
2.1. ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ	10
2.1.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр	11
2.1.2. Ханган нийлүүлэх байгууллага	12
2.1.3. Эмийн сан	13
2.2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ	16
2.3. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	19
2.3.1. Эмийн санхүүжилт	19
2.3.2. Эм эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын мэдүүлэг	22
2.3.3. Эмийн экспорт	25
2.3.4. Төрийн хяналт	26
2.3.5. Үйлдвэрлэл, борлуулалт	26
2.3.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах үйл ажиллагаа	29
2.4. ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТ	31
2.4.1. Эмийн бүртгэл	31
2.4.2. Хяналт шалгалт	34
2.4.3. Лабораторийн шинжилгээ	36
2.4.4. Эмийн аюулгүй байдал	40
2.4.5. Эмийн зар сурталчилгааны зөвшөөрөл	41
2.4.6. Эмийн зохистой хэрэглээ	42
2.4.7. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм	44
2.5. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА	45
АВЛИГААС СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЭЛ	50

ӨМНӨХ ҮГ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас “Эм зүйн салбарын үзүүлэлт-2024” эмхэтгэлийг та бүхэндээ хүргэж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн 2024 онд УИХ-аар салбарын гол хууль болох Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, салбарын эрх зүйн орчин сайжирч, илүү нарийн зохицуулалттай болж байна.

Анх 2015 онд эм зүйн салбарын хүний нөөц, эм хангамжийн байгууллага, эдийн засгийн тоон мэдээлэл болон эмийн бүртгэл, чанар аюулгүй байдал, эмийн сонголт, зохистой хэрэглээний үзүүлэлтийг тусган Эм зүйн салбарын үзүүлэлтийг эмхэтгэн гаргаж байсан ба энэ удаа арав дахь жилээс эхлэн хуулинд тусгасны дагуу “Эм, эмнэлгийн хэрэгслийн статистик үзүүлэлт”-ийг эмхэтгэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч болон бусад хэрэглэгчдийн хүртээл болгон хүргэж байна.

Манай агентлагийн хувьд байгуулагдсан цагаас эхлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.

Эрхэм эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд та бүхнийг цаашдын бодлого, төлөвлөгөө, арга хэмжээ болон судалгаа шинжилгээний ажилдаа энэхүү эмхэтгэлийг өргөнөөр ашиглана гэдэгт итгэж байна.

Н.ЭРДЭНЭБАЯР

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
АУ-НЫ ДОКТОР, ПРОФЕССОР

1

ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1.1


МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ



Монгол улсын хүн амын тоо 2024 онд 3 сая 544.8 мянга болсон байна. 2023 оноос 40.1 мянган хүнээр буюу 1.1 хувиар өссөн байна. Нийт хүн амын 1 сая 768 мянга буюу 49.9% нь нийслэлд, үлдсэн 1 сая 776 мянга буюу 50.1% нь орон нутагт амьдарч байгаа бөгөөд эрэгтэйчүүд 1 сая 736.3 мянга, эмэгтэйчүүд 1 сая 808.4 мянга байна. (Зураг 1.)

Нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл: 0-14 хүртэлх насны хүүхэд 1 сая 88.8 мянга (30.9 хувь), 15-19 насны хүүхэд 270.2 мянга (7.6 хувь), 20-39 насны хүн ам 975.9 мянга (27.5 хувь), 40-64 насны хүн ам 918.6 мянга (25.9 хувь), 65-аас дээш насны хүн ам 187.9 мянга буюу 5.3 хувийг тус тус бүрдүүлж байна.


Зураг 1. Хүн амын тоо, сонгосон онуудаар



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн сан - www.1212.mn

Монгол хүний дундаж наслалт 2024 онд улсын хэмжээнд 71.77 болж өмнөх оноос 0.3 жилээр өссөн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 77.1 эрэгтэйчүүдийн хувьд 67.92 болжээ. Монгол хүний дундаж наслалт 1992 онд 62.77 байсан ба 2024 онд 71.77 болж, сүүлийн 32 жилийн хугацаанд 9.0 жилээр нэмэгдсэн байна. (Зураг 2.)


Зураг 2. Хүн амын дундаж наслалт, сонгосон онуудаар



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн сан - www.1212.mn

Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт аймгуудаар авч үзвэл Баян-Өлгий аймгийн хүн амын дундаж наслалт 76 буюу улсын дунджаас 4.23 жилээр их, Дархан-Уул аймгийн хүн амын дунджаас 68.6 буюу улсын дундаж 3.17 жилээр бага байна. (Зураг 3.)

Зураг 3. Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр 2024 он



Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт аймаг бүсүүдээр ялгаатай байгаа ба баруун бүсэд хамгийн өндөр буюу 73.79, хангайн бүсэд хамгийн бага буюу 72.76 байна. (Хүснэгт 1.)

Хүснэгт 1. Хүн амын дундаж наслалт, бүс, аймгаар 2024 он

Аймаг, нийслэл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	71.77	67.92	77.1
Баруун бүс	73.79	70.34	76.59
Баян-Өлгий	76	72.94	78.42
Говь-Алтай	73.14	68.38	77.3
Завхан	73.07	70.69	75.5
Увс	71.7	67.41	74.99
Ховд	75.04	72.3	76.76
Хангайн бүс	72.76	70.12	76.52
Архангай	73.22	71.09	74.18
Баянхонгор	72.32	69.09	74.38
Булган	75.01	70.42	77.42
Орхон	73.66	72.92	83.7
Өвөрхангай	72.67	70.73	74.93
Хөвсгөл	69.7	66.49	74.55
Төвийн бүс	72.85	69.3	77.59
Говьсүмбэр	74.11	72.17	77.3
Дархан-Уул	68.6	64.23	74.44
Дорноговь	73.11	68.65	78.76
Дундговь	75.78	72.52	80.5
Өмнөговь	73.72	69.66	78.36
Сэлэнгэ	71.68	67.17	78.06
Төв	72.97	70.74	75.68
Зүүн бүс	73.76	69.88	77.9
Дорнод	71.27	67.34	75.54
Сүхбаатар	75.89	70.69	80.82
Хэнтий	74.13	71.63	77.35
Улаанбаатар	72.45	67.72	75.78

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн сан - www.1212.mn



» 1.2.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын зам, хоол боловсруулах, зүрх судасны, шээс бэлгийн тогтолцооны өвчин болон гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг өвчнүүд багтаж байна. 2022 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 2023-2024 онд хоол боловсруулах тогтолцооны өвчин тэргүүлж байна. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан 10000 хүн амд харгалзах тоо үзүүлэлтүүд 2023 онтой харьцуулахад өссөн байна.

№	Хүн амын өвчлөлийн шалтгаан 10000 хүн амд	2022	2023	2024
1	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1766.7	2083.1	2010
2	Амьсгалын тогтолцооны өвчин	1822.6	1930.8	1848.9
3	Зүрх судасны тогтолцооны өвчин	1308.9	1376.9	1340.9
4	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	959.5	1150.3	1088.9
5	Гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	658	767.7	820.1

2023 онтой харьцуулахад 10000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчин 81.9-өөр, хоол боловсруулах тогтолцооны өвчин 73.1-ээр, зүрх-судасны тогтолцооны өвчин 36-аар, шээс бэлгийн тогтолцооны өвчин 61.4-өөр буурсан бол гэмтэл, хордлого ба бусад шалтгаант өвчин 52.4-өөр өссөн байна. (Зураг 4.)

**Зураг 4. Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан,
10 000 хүн амд, 2020-2024 он**



» 1.2.2. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Монгол улсын хүн амын нас баралтын шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хавдар, зүрх-судасны тогтолцооны өвчин 1990 онд тэргүүлж байсан бол 1995 оноос одоог хүртэл зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдар, гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралт тэргүүлсээр байна.

№	Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд	2022	2023	2024
1	Зүрх-судасны тогтолцооны өвчин	20.3	17.1	16.91
2	Хавдар	12.8	12.8	13.23
3	Гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаант	10.1	9.1	9.38
4	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	3.7	3.6	3.59
5	Амьсгалын тогтолцооны өвчин	2.7	2.6	2.9

Урьд онтой харьцуулахад хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан 10000 хүн амд зүрх-судасны тогтолцооны өвчин -0.19 нэгжээр, хоол боловсруулах тогтолцооны өвчин 0.01 нэгжээр буурсан бол амьсгалын тогтолцооны өвчин 0.3 нэгжээр гэмтэл, хордлого ба бусад шалтгаант өвчин 0.28 нэгжээр тус тус өссөн байна. (Зураг 5.)

Зураг 5. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан,
10 000 хүн амд (2022-2024 он)



Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төв,
Эрүүл мэндийн салбарын үзүүлэлт-2024 он

2

ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2.1

ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ



Эм хангамжийн байгууллагын үзүүлэлтийг дараах чиглэлээр гаргав.

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр
2. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага
3. Эмийн сан

2024 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр 32, ханган нийлүүлэх байгууллага 466, эмийн сан 2835 байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Эм хангамжийн байгууллагын тоо, 2020-2024 он


Эм хангамжийн байгууллагын төрөл	2020		2021		2022		2023		2024	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Үйлдвэр	38	1.4%	43	1.5%	40	1.4%	33	0.97%	32	0.96%
Ханган нийлүүлэх байгууллага	384	13.9%	444	15.7%	495	13.9%	454	13.4%	466	13.9%
Эмийн сан	2343	84.7%	2335	82.8%	2595	84.7%	2916	85.7%	2835	85%
Нийт	2431	100%	2765	100%	2822	100%	3130	100%	3333	100%

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн сан - www.1212.mn

» 2.1.1. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛДВЭР

2024 онд эм, эмнэлгийн хэрэгслийн 32 үйлдвэр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулсан байна. (Зураг 6.)

Зураг 6. Үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагын тоо, 2020-2024 он



Улсын хэмжээнд 2024 онд эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх нийт 32 үйлдвэр үйл ажиллагаа явуулснаас Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан 9 үйлдвэр байна.

Тус үйлдвэрүүдийг чиглэлээр нь авч үзвэл эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, биологийн идэвхит бүтээгдэхүүн, ариутгал, халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх 51 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. (Зураг 7.)

Зураг 7. Үйлдвэрийн тоо үйл ажиллагааны чиглэлээр, 2024 он



Эмийн 27 үйлдвэр нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна. (Зураг 8.)


Зураг 8. Эмийн үйлдвэрийн тоо үйл ажиллагааны чиглэлээр, 2024 он



» 2.1.2. ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

2024 оны жилийн эцсийн байдлаар 466 ханган нийлүүлэх байгууллага тусгай зөвшөөрөлтэй байгаагаас эм импортлох-ханган нийлүүлэх байгууллага 341, эмнэлгийн хэрэглэгдэхүүн импортлох-ханган нийлүүлэх байгууллага 285, эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох-ханган нийлүүлэх байгууллага 198, лабораторийн оношилгооны хэрэгсэл импортлох-ханган нийлүүлэх байгууллага 101 тус тус байна. (Зураг 9.)

Зураг 9. Ханган нийлүүлэх байгууллагын тоо үйл ажиллагааны чиглэлээр-2024 он



► 2.1.3. ЭМИЙН САН

Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартаар эмийн санг нийтийн үйлчилгээтэй эмийн сан, эмнэлгийн эмийн сан гэж ангилна.


1. Нийтийн үйлчилгээтэй эмийн санг зэрэглэлээр дараах байдлаар ангилна.

1.1. Нэгдүгээр зэрэглэлийн эмийн сан

1.2. Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан

Улсын хэмжээнд 2024 онд нийт 2835 эмийн сан үйл ажиллагаа явуулснаас нэгдүгээр зэрэглэлийн 155 (5%), хоёрдугаар зэрэглэлийн 2680 (95%) тус тус эзэлж байна. (Зураг 10.)

Зураг 10. Эмийн сангийн тоо, зэрэглэл, эзлэх хувиар, 2024 он



Эмийн сан байршлаар нь нийслэлд 1674, орон нутагт 1161 эмийн сан үйл ажиллагаа явуулсан. Үүнээс нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа нийт эмийн сангаас нэгдүгээр зэрэглэлийн 37, хоёрдугаар зэрэглэлийн 1637 эмийн сан байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт эмийн сангаас нэгдүгээр зэрэглэлийн 118, хоёрдугаар зэрэглэлийн 1043, эмийн сан байна. (Зураг 11.)

Зураг 11. Эмийн сангийн тоо, байршил, зэрэглэлээр, 2024 он



Хүснэгт 3. Эмийн сангийн тоо байршлаар, 2023-2024 он

№	Аймаг, хотын нэр	I зэрэглэлийн эмийн сангийн тоо сумын, хувийн		II зэрэглэлийн эмийн сангийн тоо		Эргэлтийн эмийн сан		Нийт
		2023	2024	2023	2024	Сумын	Хувийн	
						2024	2024	
1	Архангай	3	3	62	63	-	63	66
2	Баян-Өлгий	2	2	67	63	7	56	65
3	Баянхонгор	13	14	36	36	-	36	50
4	Булган	-	-	36	39		39	39
5	Говь-Алтай	1	1	36	36	-	36	37
6	Говьсүмбэр	-	-	13	13	-	13	13
7	Дархан-Уул	6	6	64	70	-	70	76
8	Дорноговь	8	8	43	42	-	42	50
9	Дорнод	6	5	44	46	13	33	51
10	Дундговь	5	6	28	22	14	8	28
11	Завхан	-	-	53	54	-	54	54
12	Орхон	38	38	36	37	-	37	75
13	Өвөрхангай	-	-	69	73	-	73	73
14	Өмнөговь	2	2	59	64	13	51	66
15	Сүхбаатар	3	3	14	27	-	27	30
16	Сэлэнгэ	8	8	49	48	20	28	56
17	Төв	-	-	67	77	26	51	77
18	Увс	2	2	72	69	14	55	71
19	Ховд	15	15	33	39	15	24	54
20	Хөвсгөл	1	1	83	81	-	81	82
21	Хэнтий	4	4	47	44	-	44	48
Орон нутгийн хэмжээнд		117	118	1011	1043	122	921	1161
Улаанбаатар		37	37	1475	1637	-	-	1674
Улсын нийт тоо		154	155	2486	2680	122	921	2835

Нийслэлд үйл ажиллагаа явуулсан 1674 эмийн сангаас Баянгол дүүрэгт 315, Баянзүрх дүүрэгт 448, Сүхбаатар дүүрэгт 201, Сонгинохайрхан дүүрэгт 226, Хан-Уул дүүрэгт 321, Чингэлтэй дүүрэгт 122, Налайх дүүрэгт 21, Багахангай дүүрэгт 4, Багануур дүүрэгт 16 эмийн сан тус тус үйл ажиллагаа явуулсан байна.

2024 онд улсын хэмжээнд 330 эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгосон ба үүнээс нийслэлд 162, орон нутагт 168 тусгай зөвшөөрөл тус тус олгогдсон байна.

Хүснэгт 4. Үйл ажиллагаа явуулсан эмийн сангийн тоо, бүс нутгаар 2024 он

№	Бүсчлэл	Аймаг хотын нэр	I зэрэглэлийн хувийн эмийн сангийн тоо	II зэрэглэлийн эмийн сангийн тоо		НИЙТ
				Хувийн	Эргэлтийн	
			2024 он			
1	Баруун бүс	Баян-Өлгий	2	56	7	65
2		Говь-Алтай	1	36	-	37
3		Завхан	-	54	-	54
4		Увс	2	55	14	71
5		Ховд	15	24	15	54
6	Хангайн бүс	Архангай	3	63	-	66
7		Баянхонгор	14	36	-	50
8		Булган	-	39	-	39
9		Орхон	38	37	-	75
10		Өвөрхангай	-	73	-	73
11		Хөвсгөл	1	81	-	82
12	Төвийн бүс	Говьсүмбэр	-	13	-	13
13		Дархан-Уул	6	70	-	76
14		Дорноговь	8	42	-	50
15		Дундговь	6	8	14	28
16		Өмнөговь	2	51	13	66
17		Сэлэнгэ	8	28	20	56
18		Төв	-	51	26	77
19	Зүүн бүс	Дорнод	5	33	13	51
20		Сүхбаатар	3	27	-	30
21		Хэнтий	4	44		48
Орон нутгийн хэмжээнд				118	921	122
Улаанбаатар				37	1637	-
Улсын хэмжээнд				155	2558	122

Зураг 12. Эмийн сангийн тоо, байршлаар, 2024





Улсын хэмжээнд 2024 оны байдлаар төрийн захиргаа болон төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, эм хангамжийн байгууллагад нийт 4538 эм зүйч, 2307 эм найруулагч ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад нийт эм зүйчийн тоо 290-ээр буюу 6.8 хувиар нэмэгдэж, эм найруулагчийн тоо 141-ээр буюу 6.5 хувиар тус тус нэмэгдсэн байна. (Хүснэгт 5.)

**Хүснэгт 5. Эм зүйч, эм найруулагчийн тоо,
тусламж үйлчилгээний шатлалаар, 2021-2024 он**

Эрүүл мэндийн байгууллагууд (Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд)		Эм зүйч				Эм найруулагч			
		2021	2022	2023	2024	2021	2022	2023	2024
Багийн эмчийн салбар		0	0	0	0	1	1	1	1
Өрхийн эрүүл мэндийн төв		0	1	0	0	0	0	0	2
Тосгоны эрүүл мэндийн төв		0	1	1	0	3	10	7	11
Сумын эрүүл мэндийн төв	А зэрэглэл	15	17	12	12	25	27	26	24
	Б зэрэглэл	16	17	19	24	51	46	48	47
	В зэрэглэл	16	18	20	21	65	62	48	47
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг		4	6	7	9	7	7	7	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг		32	36	41	44	43	39	4	41
Дүүргийн нэгдсэн эмнэлэг		18	18	21	25	9	6	5	6
Аймгийн нийгмийн эрүүл мэндийн төв		0	0	0	0	0	0	0	0
Дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, НЭМҮТ		25	31	36	39	8	12	11	7
Бүсийн оношилгоо эмчилгээний төв		25	26	30	32	4	6	6	6
Тусгай мэргэжлийн төв		0	0	1	4	0	0	0	0
Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг		114	118	132	132	17	18	16	15
Амаржих газар		10	10	10	10	2	1	0	1
Түргэн тусламжийн төв		1	1	1	1	11	12	12	12
Сэргээн засах төв		0	0	0	0	0	0	0	0
Клиник/ улсын/		0	0	0	0	0	0	0	0
Клиник /Хувийн/		22	26	26	31	6	12	6	6
Ортой хувийн эмнэлэг		89	103	118	134	35	36	43	39
Сувилал		1	1	2	2	3	0	1	0
Хөнгөвчлөх асаргаа, сувилгааны төв		3	6	6	5	1	1	1	1
Сувилахуйн төв		0	0	0	0	0	0	0	0
ЭМЯ, ЭМХТ		0	0	2	0	0	0	0	0
ЭЭХХЗГ		65	65	65	71	-	-	-	-
Эрүүл мэндийн газар (аймаг, нийслэл)		8	7	5	7	2	3	3	3
Эм ханган нийлүүлэх байгууллага		135	373	357	440	117	164	143	135
Эмийн үйлдвэр		0	3	70	0	0	0	1	0
Эмийн сан		2332	2887	3206	3427	1577	1729	1753	1871
Бусад		5	8	9	8	7	6	5	4
Бүгд (Эрүүл мэндийн салбарт)		2936	3779	4197	4478	1994	2198	2147	2285
Тусгай эмнэлэг		17	19	20	21	8	11	11	12
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа эрүүл мэндийн байгууллага		11	16	19	24	6	5	5	7
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа эрүүл мэндийн байгууллагууд		1	1	1	2	0	1	1	1
Төмөр замын нэгдсэн эмнэлэг		5	7	7	7	1	1	1	1
Бусад (уурхай, үйлдвэр, албан газар, мэргэжлийн хяналтын газар гэх мэт)		8	5	4	6	1	2	1	1
Бүгд (Бусад салбарт)		42	48	51	60	16	20	19	22
Бүгд		2978	3827	4248	4538	2010	2218	2166	2307

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төв,
Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тайлан-2024 он

2024 оны байдлаар орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад 1197 эм зүйч, 1159 эм найруулагч, нийслэлд 2437 эм зүйч, 931 эм найруулагч тус ажиллаж байна. (Хүснэгт 6.)

2023 оны үзүүлэлттэй харьцуулахад орон нутгийн эрүүл мэндийн салбарт ажиллах эм зүйчийн тоо 56-аар нэмэгдэж, эм найруулагчийн тоо 42-оор нэмэгдсэн байна.

**Хүснэгт 6. Эм зүйч, эм найруулагч тоо,
аймаг нийслэлд, 2023-2024 он**

№	Бүсчлэл	Аймаг	Эм зүйч		Эм найруулагч	
			2023	2024	2023	2024
Улсын дундаж						
1	Баруун бүс	Баян-Өлгий	72	77	92	89
2		Говь-Алтай	16	21	13	20
3		Завхан	42	39	43	41
4		Увс	79	79	40	40
5		Ховд	63	70	53	58
6	Хангайн бүс	Архангай	63	70	65	70
7		Баянхонгор	59	62	45	49
8		Булган	33	28	38	39
9		Орхон	137	145	107	111
10		Өвөрхангай	74	78	68	68
11		Хөвсгөл	60	62	62	63
12	Төвийн бүс	Говьсүмбэр	15	13	17	17
13		Дархан-Уул	89	99	98	104
14		Дорноговь	39	43	70	68
15		Дундговь	16	16	27	24
16		Өмнөговь	108	101	33	33
17		Сэлэнгэ	39	36	84	87
18		Төв	28	34	57	61
19	Зүүн бүс	Дорнод	55	60	33	40
20		Сүхбаатар	22	26	29	33
21		Хэнтий	32	38	43	44
Орон нутгийн хэмжээнд			1141	1197	117	1159
Улаанбаатар			2256	2437	878	931
Улсын хэмжээнд			3397	3634	1995	2090

Улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежид эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсгөгч бэлтгэн гаргаж байна. 2024 онд нийт 565 эм зүйч мэргэжлээр төгссөн. 2023 онтой харьцуулахад эм зүйчээр төгсгөгчдийн тоо 216-аар буурсан байна.

2024 онд АШУҮИС-ийн Эм зүйн сургууль 110, ЭЗШУИС 112, Этүгэн их сургууль 117, ШАУИС 58, Энэрэл Дээд сургууль 151, Оточ манрамба дээд сургууль 0 МҮИС 17, төгсгөгч эм зүйч мэргэжлээр төгссөн байна. (Хүснэгт 7.)

Хүснэгт 7. 2020-2024 онуудад Эм зүйч /бакалавр/ төгсгөгчдийн тоо, сургуулиар

№	Сургуулийн нэр	2020	2021	2022	2023	2024
		Эм зүйч (бакалавр)				
1	АШУҮИС-Эмзүйн сургууль	83	81	108	133	110
2	ЭЗШУИС (Монос)	145	249	251	278	112
3	Этүгэн Их сургууль	78	158	86	191	117
4	ШАУИС	95	70	70	101	58
5	Энэрэл дээд сургууль	-	86	96	126	151
6	Оточ манрамба их сургууль	-	7	-	3	0
7	МҮИС	-	25	-	45	17
	Нийт	401	676	611	781	565


Улсын хэмжээнд эм зүйч болон эм найруулагч мэргэжлээр улсын болон хувийн хэвшлийн 7 их дээд сургууль боловсон хүчнийг сурган, төгсгөж байна.

2.3 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.3.1. ЭМИЙН САНХҮҮЖИЛТ

Эрүүл мэндийн салбарын төсөв 2024 онд 1.178 их наяд төгрөг болсон нь өмнөх онтой харьцуулахад 153.3 тэрбум төгрөгөөр буюу 87 хувиар өссөн байна. (Зураг 13.)

Зураг 13. Эрүүл мэндийн салбарын төсөв, тэрбум төгрөгөөр, 2015-2024 он



	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Салбарын төсөв	581.9	675.5	674.4	721.9	823.04	986.9	1069	1480	1024.8	1178.1
Эм, Эмнэлгийн хэрэгслийн төсөв	70.4	86.6	96.6	109.06	121.3	146.76	542.4	439.6	437.0	573.7
Эмийн төсвийн эзлэх хувь	12.1%	13.2%	14.3%	15.1%	14.7%	14.9%	50.7%	29.6%	42.60%	48.60%

Эх сурвалж: Эрүүл Мэндийн яам,
Шилэн данс 2024 он

Улсын хэмжээнд 2024 онд нийслэлд 737, орон нутагт 770, нийт 1507 эмийн сан Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээтэй ажилласан. (Хүснэгт 8.)


Хүснэгт 8. Эрүүл мэндийн даатгалын гэрээтэй байгууллагын тоо, бүс нутгаар 2023-2024 он

№	Аймаг, дүүргийн нэр	Байгууллагын тоо		№	Аймаг, дүүргийн нэр	Байгууллагын тоо	
		2023	2024			2023	2024
1	Архангай	36	37	18	Увс	57	58
2	Баян-Өлгий	26	29	19	Ховд	39	44
3	Баянхонгор	41	39	20	Хөвсгөл	37	38
4	Булган	29	29	21	Хэнтий	36	39
5	Говь-Алтай	26	30		Орон нутаг нийт	772	770
6	Говьсүмбэр	6	6	Улаанбаатар			
7	Дархан	41	41	1	Баянгол	131	135
8	Дорноговь	49	38	2	Баянзүрх	184	190
9	Дорнод	38	37	3	Багануур	9	9
10	Дундговь	20	19	4	Багахангай	1	1
11	Завхан	32	36	5	Налайх	9	11
12	Орхон	54	54	6	Сүхбаатар	94	98
13	Өвөрхангай	51	57	7	Сонгинохайрхан	107	123
14	Өмнөговь	44	39	8	Хан-Уул	113	120
15	Сүхбаатар	22	23	9	Чингэлтэй	49	50
16	Сэлэнгэ	39	35	Нийт		1469	1507
17	Төв	49	42				

2024 онд 502 нэрийн эмэнд 134.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна. Өмнөх онтой харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн санхүүжилтийн хэмжээ 44.4 тэрбум буюу 49.3 хувиар нэмэгдсэн байна. (Зураг 14.)

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон эмийн санхүүжилт нь сүүлийн 6 жилийн байдлаар өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 14. ЭМД-ын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлт, тэрбум төгрөгөөр, 2019-2024 он



Эх сурвалж: Эрүүл Мэндийн Даатгалын ерөнхий газар, Үйл ажиллагааны тайлан 2024 он

Эрүүл Мэндийн Даатгалын Сангаас хамгийн их хөнгөлөлт олгосон 10 нэрийн эмийг жагсаалтаар харуулав. (Зураг 15.)

Зураг 15. ЭМД-ын сангаас хөнгөлөлтөөр хамгийн их олгосон 10 нэрийн эм, мөнгөн дүнгээр, 2024 он



» 2.3.2. ЭМ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ИМПОРТ, ЭКСПОРТЫН МЭДҮҮЛЭГ


Монгол улсад 2024 оны жилийн эцсийн байдлаар 87 улсын 478 үйлдвэрлэгчийн (давхардсан тоогоор) 1107 (худалдааны нэршлээр) нэр төрлийн эмэнд импортын мэдүүлэг олгосон байна. (Хүснэгт 9.)

Хүснэгт 9 . Импортолсон эм, 2022-2024 он

Он	Эмийн төрөл	Эмийн тоо (Олон улсын нэршлээр)	Эмийн тоо (Худалдааны нэршлээр)	Импортолсон улсын тоо (давхардсан тоогоор)	Үйлдвэрлэг чийн тоо
2022	Нийт	916	1724	51	514
Үүнээс	Биобэлдмэл	14	23	10	15
	Антибиотик	79	226	30	107
	Уламжлалт эм	3	25	4	4
	Бусад төрлийн эм	820	1470	51	458
2023	Нийт	872	1849	51	512
Үүнээс	Биобэлдмэл	15	23	10	16
	Антибиотик	74	203	29	105
	Уламжлалт эм	5	31	5	11
	Бусад төрлийн эм	778	1592	51	454
2024	Нийт	694	1107	87	478
Үүнээс	Биобэлдмэл	19	22	8	16
	Антибиотик	105	237	29	122
	Уламжлалт эм	6	33	3	7
	Бусад төрлийн эм	564	815	47	333

Импортлолсон эмийг олон улсын АТС ангиллаар ангилж авч үзвэл А ангилал буюу хоол боловсруулах замын эмгэгт хэрэглэх эм (227 нэр төрөл), J ангилал буюу нянгийн эсрэг хэрэглэх эм (237 нэр төрөл), R ангилал буюу амьсгалын тогтолцооны эмгэгт хэрэглэх эмийг (177 нэр төрөл) хамгийн их импортлолсон байна. (Зураг 16.)

Зураг 16. Импортлолсон эм худалдааны нэрээр, АТС кодоор, 2024 он




2023 онтой харьцуулахад эм, эмийн түүхий эд, стандарт бодист олгосон импортын мэдүүлэг 981-ээр буурч, эмнэлгийн хэрэгсэл, эмийн туслах материал 202, оношлуур урвалж 391, төрийн хяналтын мэдүүлэг 121, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн импортын мэдүүлэг 12-оор тус тус өссөн үзүүлэлттэй байна. (Зураг 17.)

Зураг 17. Олгосон импортын мэдүүлгийн тоо, төрлөөр, 2023-2024 он




2024 онд нийт 324 байгууллагад 8766 импортын мэдүүлэг олгосон ба өмнөх онтой харьцуулахад мэдүүлэг авсан байгууллагын тоо 15-аар буурч, олгосон мэдүүлгийн тоо 118-аар нэмэгдсэн байна. (Зураг 18.)

Зураг 18. Олгосон импортын мэдүүлэг, мэдүүлэг авсан байгууллагын тоо, 2022-2024 он



2024 онд олгосон нийт бүртгэлтэй эмийн 1684 импортын мэдүүлгээс 46.7%-ийг Алтан булаг, 38.7%-ийг Чингис хаан, эмнэлгийн хэрэгслийн 4376 импортын мэдүүлгээс 60.2%-ийг Чингис хаан, 38.3%-ийг Замын-Үүдийн боомтоор тус тус импортлохоор мэдүүлсэн байна. (Зураг 19.)

Зураг 19. Импортлосон эм, эмнэлгийн хэрэгсэл хилийн боомтоор, 2024 он



► 2.3.3. ЭМИЙН ЭКСПОРТ


Монгол улсаас 3 ханган нийлүүлэх байгууллага Бүгд Найрамдах Унгар улс болон Бүгд найрамдах Польш улс руу уламжлалт эмийг экспортолж байна.

2024 онд 881,759,835 төгрөгийн 146 /давхардсан тоогоор/ нэр төрлийн уламжлалт эмэнд экспортын мэдүүлэг олгосон нь 2023 онтой харьцуулахад 39.1%-иар буурсан ба тан эмийн экспорт 18.7 сая, талх эмийн экспорт 402.2 сая, үрэл эмийнх 145.6 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. (Хүснэгт 10.)

Хүснэгт 10. Экспортолсон уламжлалт эм мөнгөн дүнгээр, сая төгрөгөөр 2022-2024 он

№	Эмийн хэлбэр	2022		2023		2024	
		Нэр төрөл	Мөнгөн дүн, сая төгрөг	Нэр төрөл	Мөнгөн дүн, сая төгрөг	Нэр төрөл	Мөнгөн дүн, сая төгрөг
1	Тан эм	51	120,029,038	116	174,435,978	31	155,731,818
2	Талх эм	122	306,436,828	74	791,853,847	88	389,607,105
3	Үрэл эм	42	254,314,150	35	482,077,534	27	336,420,912
	Нийт дүн	215	680,780,016	225	1,448,367,359	146	881,759,835


Зураг 20. Экспортолсон эмийн мөнгөн дүн, сая төгрөгөөр, 2021-2024 он



► 2.3.4. ТӨРИЙН ХЯНАЛТ

2024 онд 187 мэдүүлгээр шинжилгээ болон судалгааны зориулалтаар 22 нэр төрлийн 6409 сорьцыг төрийн хяналтын дор Монгол улсын хилээр нэвтрүүлсэн байна. (Зураг 21.)

Зураг 21. Улсын хилээр төрийн хяналтан дор экспортолсон барааны мэдээлэл, 2024 он



► 2.3.5. ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий 32 эмийн үйлдвэр бүртгэлтэй байна. (Зураг 22.)

Зураг 22. Дотоодын үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл, давхацсан тоогоор 2024 он



Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Дотоодын 18 үйлдвэр 2024 онд үйл ажиллагаа явуулж нийт 122.1 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, уламжлалт эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 121.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.



Үүнээс: 108.2 тэрбум төгрөгийн европ эм үйлдвэрлэж, 108.3 тэрбум төгрөгийн борлуулалт, 4.2 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж, 3.1 тэрбум төгрөгийн борлуулалт, 2.9 тэрбум төгрөгийн биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2.8 тэрбум төгрөгийн борлуулалт, 5.33 тэрбум төгрөгийн уламжлалт эм үйлдвэрлэж, 5.34 тэрбум төгрөгийн борлуулалт, 1.3 тэрбум төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 1.5 тэрбум төгрөгийн борлуулалт тус тус хийсэн байна. 2023 онтой харьцуулахад нийт үйлдвэрлэл үнийн дүнгээр 10.1 хувиар өсөж тоо хэмжээгээр 20 хувиар буурсан үзүүлэлттэй байна. (Зураг 23.)

Зураг 23. Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл сүүлийн 3 жил /тэрбум төгрөг/



2024 онд эмийн үйлдвэрүүд нийт 615 нэр төрлийн эм үйлдвэрлэснээс 265 нэрийн эм (43%), 46 нэрийн эмнэлгийн хэрэгсэл (7%), 24 нэр төрлийн Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн (4%), 251 нэрийн уламжлалт эм (41%), 29 нэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодис (5%) үйлдвэрлэсэн байна. (Зураг 24.)

Зураг 24. Эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрлийг хувиар



Нийт дотоодын эмийн зах зээлийн 95 хувь буюу 116.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP)-ын шаардлага хангасан 9 эмийн үйлдвэрт үйлдвэрлэсэн байна.

Дотоодын 9 эмийн үйлдвэр “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” GMP-ийг нэвтрүүлснээс тарилгын эмийн үйлдвэр 3, женерик эмийн үйлдвэр 4, уламжлалт эмийн үйлдвэр 2 тус тус байна. (Зураг 25.)


Зураг 25. GMP-ийн батламж авсан үйлдвэрүүдийн он цагийн дараалал




» 2.3.6. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

2024 онд эмийн суурь үнийн дүнгээр 612.2 тэрбум төгрөгийн импорт хийсэн нь 2023 онтой харьцуулахад импорт 84 тэрбум төгрөг буюу 15.9% өссөн байна. (Зураг 26.)

Зураг 26. Эмийн импорт,
тэрбум төгрөгөөр, 2020-2024 он



2024 онд нийт 612.2 тэрбум төгрөгийн эмийн импорт хийснээс дараах 15 улсаас 525.5 тэрбум төгрөг буюу нийт импортын 85.8 хувийг импортолсон байна. (Зураг 27.)



Зураг 27. Хамгийн их эмийн импорт
хийсэн улс, эзлэх хувиар, 2024 он

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Ерөнхий гэрээний худалдан авалт: 2024 онд Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим дэлгүүрээс 176 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг /149 нэр төрлийн эм, 27 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл/ 60,337,880,801 /жаран тэрбум, гурван зуун гучин долоо сая, найман зуун наян мянга найман зуун нэг/ төгрөгөөр худалдан авч, улсын төсөвт хийсэн хэмнэлт 1,997,100,816 /нэг тэрбум есөн зуун ерэн долоо сая нэг зуун мянга найман зуун арван зургаа/ төгрөг байна.

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий гэрээгээр худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгын нийт дүн, хэмнэлт:

Төрийн өмчийн байгууллагууд Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим дэлгүүрээс 2024 оны жилийн эцэст 60.3 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийж, улсын төсөвт 1.99 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Өмнөх онтой харьцуулахад Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим дэлгүүрээс захиалга 17.1 тэрбумаар өсөж, улсын төсөвт хэмнэлтийн дүн 2.1 тэрбумаар буурсан байна. (Зураг 28.)

Зураг 28. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгын нийт дүн, хэмнэлт, тэрбум төгрөгөөр (2019-2024 он)



» 2.4.1. ЭМИЙН БҮРТГЭЛ

Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм:

2024 онд Монгол Улсад нийт 229 нэрийн эм бүртгэгдсэн байна. Үүнд:

- 224 нэрийн импортын эм
- 5 нэрийн үндэсний үйлдвэрийн эм байна.



2024 оны байдлаар Монгол Улсад 26 үйлдвэрлэгчийн 785 нэрийн үндэсний үйлдвэрийн эм бүртгэлтэй байна. Үүнээс:

- 9.3%-ийг (375 нэрийн эм) үндэсний үйлдвэрийн эм
- 10.2%-ийг (410 нэрийн эм) үндэсний үйлдвэрийн уламжлалт эм тус тус эзэлж байна.

Бүртгэлтэй эмийн олгох нөхцөл /хувиар/ (2024 он)

2024 оны байдлаар Монгол Улсад 57 улсын 791 үйлдвэрлэгчийн нийт 4020 нэрийн эм бүртгэлтэй байна. Үүнээс:

- Жоргүй олгох 27.8% (1116 нэрийн эм)
- Жороор олгох 69.6% (2799 нэрийн эм)
- Эмнэлгийн нөхцөлд хэрэглэх 1.6% (65 нэрийн эм)
- Сэтгэцэд нөлөөт эмийн жороор олгох 0.7% (27 нэрийн эм)
- Мансууруулах эмийн жороор олгох 0.3% (13 нэрийн эм) эм байна.

Бүртгэлтэй мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн тоо

2024 онд Монгол Улсад бүртгэгдсэн 5 улсын 5 үйлдвэрлэгчийн нийт 13 нэрийн мансууруулах эм, 9 улсын 14 үйлдвэрлэгчийн нийт 27 нэрийн сэтгэцэд нөлөөт эм бүртгэлтэй байна.

2024 онд дараах 10 улсаас хамгийн олон эм бүртгэгдсэн байна. Үүнд:

1. Монгол 19.53%	4. ОХУ 5.4%	7. БНХАУ 4.43%	10. Турк 2.4%
2. БНЭУ 11.8%	5. Герман 5.12%	8. Индонез 4.2%	11. Бусад 27.3%
3. БНСУ 11.44%	6. ИБУИНВУ 4.45%	9. Словени 3.9%	

Хүснэгт 11. Хүний анатомийн бүтцэд суурилсан кодын ангиллаар авч үзвэл:

Хүний анатомийн бүтцэд суурилсан код (АТС)	Эмийн тоо	Хувь
A-Alimentary tract and metabolism - Хоол боловсруулах замын эмгэгт хэрэглэх эм	524	13.03%
B- Blood and blood forming organs -Цус, цус төлжүүлэх эрхтний эмгэгт хэрэглэх эм	251	6.20%
C-Cardiovascular system-Зүрх судасны тогтолцооны эмгэгт хэрэглэх эм	378	9.40%
D-Dermatologicals- Арьсны эмгэгт хэрэглэх эм	172	4.28%
G-Genito urinary system and sex hormones-Шээс, бэлгийн тогтолцоо болон бэлгийн даавар шавжийн эсрэг бэлдмэл	167	4.20%
H-Systemic hormonal preparations sex hormones and insulins-Бэлгийн даавар, инсулинаас бусад тогтолцооны дааврын бэлдмэл	76	1.90%
J-General antiinfective for systemic use-Нянгийн эсрэг хэрэглэх эм	637	1.90%
L-Antineoplastic and immunomodulating agents-Хавдрын эсрэг болон дархлаа нөлөөт бодис	197	1.90%
M-Musculo skeletal system-Булчин, тулгуур эрхтэний тогтолцооны эмгэгт хэрэглэх эм	214	1.90%
N-Central nervous system-Төв мэдрэлийн тогтолцооны эмгэгт хэрэглэх эм	351	1.90%
P-Antiparasitic products, insecticides and repellents-Паразит, шавьжийн эсрэг бэлдмэл	17	1.90%
R-Respiratory system-Амьсгалын тогтолцооны эмгэгт хэрэглэх эм	363	1.90%
S-Sensory organs-Мэдрэхүйн эрхтэний эмгэгт хэрэглэх эм	127	1.90%
T-Traditional medicine-Уламжлалт эм	465	1.90%
V-Various-Бусад	81	1.90%
НИЙТ	4020	100%

Эмийн түүхий эдийн тоо

2024 онд Монгол Улсад 18 нэрийн эмийн түүхий эд бүртгэгдсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсад 8 улсын 120 үйлдвэрлэгчийн 190 нэрийн эмийн түүхий эд бүртгэлтэй байна.

Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний тоо

2024 онд Монгол Улсад нийт 588 нэрийн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн бүртгэгдсэн. 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсад 47 улсын 358 үйлдвэрлэгчийн нийт 1962 эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн бүртгэлтэй байна. Үүнээс:

- 1892 нэрийн импортын эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн
- 70 нэрийн үндэсний эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн тус тус бүртгэгдсэн байна.

2024 онд Монгол Улсын эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэлд дараах 10 улс хамгийн олон эм бүртгүүлсэн байна. Үүнд:

№	Улс	ЭМНБ тоо	Хувь
1	АНУ	499	25.4
2	ОХУ	200	10.2
3	БНСУ	155	7.9
4	Герман	111	5.66
5	Польш	99	5.05
6	ИБУИНВУ	94	4.79
7	Австрали	90	4.59
8	Япон	82	4.2
9	Канад	72	3.67
10	Монгол	70	3.57
	Бусад	490	24.97


Зураг 30. Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний бүртгэл (2014-2024 он)



Лабораторийн оношилгооны хэрэгслийн тоо

2024 онд Монгол Улсад 246 нэрийн лабораторийн оношилгооны хэрэгсэл бүртгэгдсэн байна. 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсад 23 улсын 114 үйлдвэрлэгчийн 1624 нэрийн лабораторийн оношилгооны хэрэгсэл бүртгэлтэй байна. (Зураг 31.)

Зураг 31. Лабораторийн оношилгооны хэрэгслийн бүртгэл (2019-2024)



► 2.4.2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газраас эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагад Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн хяналтын шалгалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт, шалгалтыг хийж байна.


2024 онд 232 эм ханган нийлүүлэх байгууллага, 511 эмнэлэг, 968 эмийн сан нийтдээ 1711 эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагад төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Өмнөх оны хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоотой харьцуулахад 1040 байгууллагаар буюу 2,5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. (Зураг 32.)

Зураг 32. Хяналт шалгалтад хамрагдсан эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагын тоо, 2016-2024 он




2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад 185 эмнэлэг, 110 эм ханган нийлүүлэх байгууллага, 277 эмийн сан нийтдээ 572 байгууллага хамруулсан бөгөөд хяналтын хуудсаар үнэлэхэд хяналт шалгалтад хамрагдсан нийт байгууллагын 59,2% буюу 339 байгууллага бага эрсдэлтэй, 36,5% буюу 209 байгууллага дунд эрсдэлтэй, 4,1% буюу 24 байгууллага их эрсдэлтэй үнэлэгдсэн. (Зураг 33.)

Зураг 33. Төлөвлөгөөт хяналт шалгалт 2024 он



2024 оны жилийн эцсийн байдлаар 1711 эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллага хяналт шалгалтад хамрагдсан бөгөөд тусгай зөвшөөрөлтэй нийт эмийн сангийн 33.1%, эрүүл мэндийн байгууллагын 21.1%, эм ханган нийлүүлэх байгууллагын 51.1%-ийг хяналт шалгалтад хамруулсан байна. (Зураг 34.)

Зураг 34. Эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагын хяналт шалгалтад хамрагдалтын хувь, 2016-2024 он



2024 онд Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй 174 нэр төрлийн 11393 ширхэг, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 289 нэр төрлийн 5606 ширхэг, хаяг шошгын зөрчилтэй 2 нэр төрлийн 483 ширхэг, хадгалалтын горим алдагдсан 5 нэр төрлийн 53024 ширхэг нийт 134,5 сая төгрөгийн үнийн дүн бүхий зөрчилтэй эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг хяналт шалгалтаар илрүүлж холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэсэн. (Хүснэгт 12)

Хүснэгт 12. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй бүтээгдэхүүний тоо, 2015-2024 он

Он	МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй		Чанарын шаардлага хангахгүй							
			Хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан		Хаяг шошгын зөрчилтэй		Хадгалалтын дэглэм алдагдсан		Лабораторит шинжлүүлсэн дээж	
	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэр төрөл	Тоо ширхэг
2015	129	2291	223	5275	134	6481	13	190	-	-
2016	131	2703	420	3060	-	-	59	1370	-	-
2017	138	13310	350	11606	32	6809	49	1205	82	15
2018	169	44168	35	678	-	-	1	1109	73	8
2019	316	16906	308	9272	11	122	14	180	89	17
2020	178	12379	328	23927	65	3479	3	120	20	3
2021	109	9287	592	19862	7	3658	61	15032	126	4
2022	5	305	397	5932	2	131	-	-	-	-
2023	14	4642	655	23548	-	-	5	83	2	180
2024	174	11393	289	5606	2	483	5	53024	12	435
Нийт	1363	117384	3597	108766	253	21163	210	72313	404	662

2024 онд хяналт шалгалтаар хадгалалтын дэглэм алдагдсан болон Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй бүтээгдэхүүнийг худалдсан зөрчил хамгийн их илэрсэн.

Зураг 35. Чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүний нэр төрөл болон тоо ширхгээр, 2024 оны жилийн эцсийн байдлаар



► 2.4.3. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ

Эм шинжлэх лаборатори нь дараах хууль эрх зүйн болон холбогдох стандарт, дүрэм журам, зааврын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд:

- “Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн Гуравдугаар бүлэг “Эмийн хяналт, зохицуулалт 19.0 дүгээр зүйл
/2024 оны 06 сарын 05-ны өдрийн шинэчилсэн найруулга/
- “Төрийн хяналт шалгалтын тухай хууль” 4.1.7.-д “хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх”, 5.5.-д “Хяналт шалгалтын бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус мэргэжлийн бусад байгууллага, шинжээч, шинжилгээний байгууллага, иргэнийг татан оролцуулж болно.”
- “Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хууль” 3.1.5-д Тохирлын үнэлгээг хэрэгжүүлэгч байгууллага-сорилтын лаборатори, 14 дүгээр зүйл “Сорилтын лаборатори”-д тавигдах шаардлага, 16. дугаар зүйл “Баталгаажуулалт”
- Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018
- “Эмийн хяналтын лабораторийн зохистой дадал GLP” WHO Technical Report Series, No. 957, 2010, Annex 1
- Эмийн микробиологийн лабораторийн зохистой дадал GLP” WHO Technical Report Series, No. 961, 2011, Annex 2
- Эмийн үйлдвэрийн зохистой дадал Good Manufacturing Practices for pharmaceutical products: main principles” WHO Technical Report Series, No. 961, 2011, Annex 3

Эм шинжлэх лаборатори нь стандартын тохирлын болон тандалт судалгааны шинжилгээг үндэсний болон олон улсын фармакопейн аргачлалаар шинжилж байна. Үүнээс стандартын тохирлын шинжилгээгээр дараах төрлийн дээжинд шинжилгээ хийгдэж байна.

- 1.Хяналтын дээж буюу улсын байцаагч нарын хяналт шалгалтын явцад авсан дээж
- 2.Монгол улсын хүний эм, биологийн идэвхит бүтээгдэхүүний шинэ бүртгэлийн дээж болон бүртгэл сунгалтын дээж
- 3.Үндэсний эмийн үйлдвэрүүдийн шинээр зохион бүтээж үйлдвэрлэх, эм биологийн идэвхит бүтээгдэхүүн, уламжлалт эмийн стандарт фармакопейн өгүүллийн төслийн дээжинд шинжилгээг хийдэг.

Тандалт судалгааны шинжилгээгээр цагдаа, тагнуулын байгууллага, хил гаалийн байгууллагаас ирсэн хууль бус, сэжигтэй, хуурамч эмийн дээж болон эмийг зах зээлд гаргасны дараах тандалт судалгааны авсан дээжинд тус тус шинжилгээ хийж байна.

Эм шинжлэх лабораторийн шинжилсэн дээжийн тоо хэмжээг сүүлийн 7 жилийн байдлаар буюу 2018-2024 оны судалгааг дэлгэрэнгүй харуулав. Эм шинжлэх лаборатори нь 2018 онд нийт 1517, 2019 онд 1933, 2020 онд 2602, 2021 онд 1727, 2022 онд 1957, 2023 онд 2535, 2024 онд 2577 дээжийг шинжилсэн байна. (Зураг 36.)

Зураг 36. Шинжилгээнд хамрагдсан нийт дээжийн сүүлийн 7 жилийн тоо



2024 оны дээжийн тоог өмнөх онуудтай харьцуулахад 2021 он 1.47%, 2022 оноос 1.31%, 2023 оноос 1.02%-р өссөн байна.

2024 оны байдлаар лабораторийн шинжилгээнд хамрагдсан нийт дээжийн мэдээлэлд үндэслэн, үндэсний эм болон импортын эмийн дээжийн тоог харьцуулан тооцоход үндэсний эмийн дээж 26.62%, импортын эмийн дээж 73.38%-г эзэлж байна. (Зураг 37.)

Нийт шинжилсэн дээжийн гарал үүслээр нь ангилахад 2018 онд импортын эм 59.2 хувь байсан бол 2024 онд 73.38 хувь болж нэмэгдсэн байна.

Зураг 37. Лабораторийн шинжилгээнд хамрагдсан дээжийн гарал үүсэл



2018 онд лабораторийн шинжилгээнд хамрагдсан 1517 дээжний 192 дээж шаардлага хангаагүй бол 2024 онд 2577 дээж шинжилгээнд хамрагдсаны 92 дээж шаардлага хангаагүй байна. (Зураг 38.)

Зураг 38. Шинжилгээнд хамрагдсан дээжийн тоо ба шаардлага хангаагүй дээжийн тоо 2017-2024



Шинжилгээнд хамрагдсан дээжийн тоог шаардлага хангаагүй дээжийн тоотой харьцуулахад 2018 оноос хойш шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь тогтмол буурч байна. (Хүснэгт 13)


Хүснэгт 13. Дээжийн тоо ба шаардлага хангаагүй дээжийн тоо

Он	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Эзлэх хувь	12.78%	10.20%	5.53%	5.85%	8.99%	5.30%	3.57%

Лабораторийн шинжилгээнд хамрагдсан нийт дээжийн шаардлага хангаагүй дээжийн тоон мэдээлэлд үндэслэн, шаардлага хангаагүй дээжийг үндэсний үйлдвэрийн дээж, импортын дээжийг харьцуулан тооцоход үндэсний үйлдвэрийн дээж 60.87%, импортын дээж 39.13% эзэлж байна. (Зураг 39.)

2018 онд импортын дээж 12.5 хувийг эзэлж байсан бол 2024 онд 60.87 хувь болж 48.37 хувиар нэмэгдсэн байна. Үндэсний үйлдвэрийн дээж 2018 онд 87.5 хувь буюу хамгийн их шинжилгээнд хамрагдсан байна.

Зураг 39. Шаардлага хангаагүй дээжийн гарал үүсэл



2024 онд шаардлага хангаагүй дээжүүдийг зах зээлийн өмнөх болон дараах байдлаар авч үзвэл:

2024 оны байдлаар лабораторийн шинжилгээнд хамрагдсан шаардлага хангаагүй 92 дээжийн мэдээлэлд үндэслэн, зах зээлийн өмнөх болон дараах дээжийн тоог харьцуулан тооцоход зах зээлийн өмнөх дээж 35.86%, зах зээлийн дараах дээж 64.0%-г эзэлж байна. Зах зээлийн өмнөх дээжийн хувьд Үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийн төсөл, MNS төсөл, эмийн шинэ бүртгэлийн дээжийн мэдээллийг оруулав. (Зураг 40.)

Зураг 40. Шаардлага хангаагүй дээжийн зах зээлийн өмнөх болон дараах дээжийн тоо



» 2.4.4. ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Үндэсний болон олон улсын түвшинд эмийн гаж нөлөө мэдээлэх үйл ажиллагаа нь ЭХХЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам”-аар зохицуулагдаж байна.

2024 онд нийт бүртгэгдсэн 244 гаж нөлөөний тохиолдлын шалтгаан хамаарал, эрсдэлийн үнэлгээг хийж, Эм судлалын салбар зөвлөлийн 10 удаагийн хурлаар хэлэлцүүлж, мэдээлэх шаардлагатай гэж үзсэн 21 гаж нөлөөний мэдээллийг УППСАЛА төвийн олон улсын мэдээний санд мэдээлсэн.

Эм бүртгүүлэгч байгууллагаас нийт 796 эмийн аюулгүй байдлын хугацаат тайланг мэдүүлж, ЭССЗ-ийн 10 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн ба аюулгүй байдлын мэдээлэлд орсон өөрчлөлт байхгүй байна. (Зураг 41.)

2023 оны мэдээтэй харьцуулахад Эмийн гаж нөлөөний тохиолдол 1.3 дахин, эмийн аюулгүй байдлын хугацаат тайлан 1.5 дахин тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Эмийн гаж нөлөө илэрсэн эмийг АТС ангиллаар харвал 2024 онд бүртгэгдсэн нийт 244 тохиолдлын хамгийн их нь буюу 38.1%-ийг нянгийн эсрэг эм хэрэглэсэнтэй холбоотой бүртгэгдсэн тохиолдол эзэлж байна. (Зураг 42.)



» 2.4.5. ЭМИЙН ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ЗӨВШӨӨРӨЛ


ЭМС-ын 2021 оны А/144 дугаар тушаалаар баталсан “Хүний эмийн зөвлөлийн Мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.2.2-т заасны дагуу Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах жоргүй олгох эм, Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн зар сурталчилгааны агуулгыг хянаж, баталгаажуулж байна.

Тус хурлаар 2024 онд 90 нэрийн бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг хянаж баталгаажуулснаас 74 нэрийн эм, 16нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүн байна. (Зураг 43.)

Зураг 43. Зураг. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнд олгосон зар сурталчилгааны тоо



Зураг 44. Зөвшөөрөл олгосон зар сурталчилгааны тоо (2016-2024)




► 2.4.6. ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

НЯНГИЙН ЭСРЭГ ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

2024 оны эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайланг ирүүлсэн 64 байгууллагад нийт 618,426 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн ба эмчилгээнд хэрэглэсэн эмийн 18%-д нянгийн эсрэг эмийг хэрэглэсэн байна. Хэрэглэсэн нийт нянгийн эсрэг эмийн 51%-г тарилга хэлбэрээр хэрэглэсэн байна. Аймаг, нийслэл, тусгай мэргэжлийн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт дунджаар 2021 онд 3 эмчлүүлэгч тутмын 1 (31.1%)-д, 2022 онд 4 эмчлүүлэгч тутмын 1 (25.5%)-д, 2023 онд нийт эмчлүүлэгчдийн 25.1%, 2024 онд нийт эмчлүүлэгчдийн 26.5%-д тус тус мэдрэг чанарын шинжилгээг хийжээ. (Зураг 45.)


Зураг 45. Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон шинжилгээний хамрагдалтыг хувиар тооцсон харьцуулалт /2021-2024 он/




Нянгийн эсрэг эмийн хэрэглээний индекс 2021 онд 3007.58 ӨТТ/100 ор хоног, 2022 онд 5569.18 ӨТТ/100 ор хоног, 2023 онд 2804 ӨТТ/100 тус тус байсан бол 2024 онд 4196.74 ӨТТ/100 ор хоног байна.

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага болон 40-өөс дээш ор бүхий хувийн эмнэлгүүд болон төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагад хэрэглэгдсэн нянгийн эсрэг эмийн хэрэглээг ӨТТ/100 ор хоногоор хувиар тооцон 2021-2023 оны үзүүлэлттэй харьцуулан үзүүллээ. (Зураг 46.)

Зураг 46. Эмнэлгүүдийн нянгийн эсрэг эмийн хэрэглээг ӨТТ/100 ор хоногоор хувиар тооцсон харьцуулалт /2021-2024 он/



2024 онд хэрэглэгдсэн нянгийн эсрэг эмүүдээс дараах эмүүдийг нянгийн эсрэг эмийн хэрэглээний индексээр тооцон 2021-2023 оны үзүүлэлттэй харьцуулсан ба левофлоксацин 500 мг шахмал, ципрофлоксацин 500 мг шахмалын хэрэглээ өмнөх жилээс нэмэгдсэн байна. (Зураг 47.)



Зураг 47. Нянгийн эсрэг эмийн хэрэглээний индексийг нэр төрлөөр харьцуулсан тоо

2024 онд эмнэлэгт хэрэглэгдсэн нянгийн эсрэг эмийн хэрэглээг ДЭМБ-н AWaRe ангиллын дагуу ангилан хувиар тооцон 2021-2023 оны үзүүлэлттэй харьцуулсан ба 2024 онд хэрэглэгдсэн нянгийн эсрэг эмийн 46.6% хүртээмжтэй байлгах, 53% хянах бүлгийн эм байна. (Хүснэгт 14)

Хүснэгт 14. Нянгийн эсрэг эмийн хэрэглээ AWaRe ангилал, хувиар, 2021-2024 он

AWaRe ангилал	2021	2022	2023	2024
Access-хүртээмжтэй байлгах	41.6%	72.9%	47.8%	46.6%
Watch-хянах	58.3%	27%	52%	53%
Reserve-нөөцлөх	0.1%	0.1%	0.1%	0.0008%


► 2.4.7. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМ

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 02 сарын 24-ний өдрийн 68 дугаар тушаалаар батлагдсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх” журмын дагуу аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас хэвлүүлж, түгээсэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жорын тайлан, мансууруулах эмийн хэрэгцээний төлөвлөгөөг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар хүлээн авч байна.


Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй 10, үйлдвэрлэх зөвшөөрөлтэй 3 аж ахуйн нэгж байна.

Орон нутагт 10259, нийслэлд 6910, нийт 17169 мансууруулах эмийн жорын маягт, харин сэтгэцэд нөлөөт эмийн жорыг орон нутагт 30993, нийслэлд 30897, нийт 61890 жорын маягыг 2024 онд зарцуулсан байна. (Зураг 47.)

Зураг 47. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын зарцуулалтын тоо 2024 он



Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг нийслэл болон орон нутгаар 2023, 2024 он



2.5

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШАЛГАЛТ

ТОХИРУУЛГА



Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 10 дугаар зүйлийн 10.3 -д тус тус заасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын асуудлыг хариуцан ажилладаг.

Монгол улсын Шадар сайдын 2015 оны 117 дугаар тушаалаар шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээ, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 249 дүгээр тушаалаар “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх тухай журам”, 2018 оны 345 дугаар тушаалаар тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга аргачлал тус тус батлагдсан.


Үүний дагуу эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа амьсгалын аппарат, дефибриллятор, дусал болон тариурын автомат шахуурга, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, унтуулгын аппарат, нярайн дулаацуулах ширээ, нярайн инкубатор, өвчтөний хяналтын монитор, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, хэт авиан оношилгооны аппарат, цахилгаан мэс заслын аппарат, рентген аппарат, пульсоксиметр буюу 14 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжид олон улсын жишигт нийцсэн 11 нэр төрлийн 40 анализатор, симулятор ашиглан шалгалт тохируулга хийж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажиллаж байна. (Зураг 48.)

Зураг 48. Монгол улсад ашиглагдаж байгаа шалгалт тохируулгын анализатор, симулятор



Сүүлийн 5 жил буюу 2020-2024 онуудад давхардсан тоогоор нийт 937 эрүүл мэндийн байгууллагын 9888 эмнэлгийн тоног төхөөрөмж шалгалт тохируулгад хамрагдсан ба дэлгэрэнгүй мэдээллийг нэгдүгээр зурагт харуулав. (Зураг 49)

Зураг 49. Шалгалт тохируулгад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо, (2020-2024 он)




Шалгалт тохируулгад 2020-2024 онд доор дурдсан 937 эрүүл мэндийн байгууллагын 14 нэр төрлийн 9889 эмнэлгийн тоног төхөөрөмж шалгалт тохируулгад хамрагдсан. Үүнээс 2024 онд 2584 эмнэлгийн тоног төхөөрөмж шалгалт тохируулгад хамрагдсан. (Хүснэгт 15)

Хүснэгт 15. Шалгалт тохируулгад хамрагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо, 2020-2024 он

№	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр	Шалгалт тохируулга хийсэн он					Нийт
		2020	2021	2022	2023	2024	
1	Амьсгалын аппарат	107	73	91	110	105	486
2	Дефибриллятор	104	30	87	82	138	441
3	Дуслын автомат шахуурга	239	86	132	171	240	868
4	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	304	88	195	226	248	1061
5	Наркозын аппарат	77	16	164	44	78	379
6	Нярайн дулаацуулагч	100	8	50	41	-	199
7	Нярайн инкубатор	60	7	17	20	-	104
8	Өвчтөний хяналтын монитор	547	148	10	371	543	1619
9	Рентген аппарат	35	13	345	27	44	464
10	Тариурын автомат шахуурга	338	111	15	238	332	1034
11	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	517	186	275	319	381	1678
12	Хэт авиан оношлогооны аппарат	332	74	166	211	263	1046
13	Цахилгаан мэс заслын аппарат	126	31	77	64	103	401
14	Пульсоксиметр	-	-	-	-	109	109
НИЙТ		2886	871	1624	1924	2584	9889

Шалгалт тохируулгад 2020-2024 онуудад хамрагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үр дүн гарган хоёрдугаар зурагт харуулав. (Зураг 50.)

Зураг 50. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үр дүн (2020-2024 он)



Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын анализатор, симуляторын жагсаалт

Америкийн нэгдсэн улсын Fluke biomedical Co.,Ltd үйлдвэрийн нэгдүгээр хүснэгтэд дурдсан 11 нэр төрлийн 40 симулятор, анализатортай. Тус хэмжлийн анализатор, симуляторыг олон улсын хэмжил зүйн байгууллагаар жилд бүр баталгаажуулалт хийлгэж чанарын шаардлагыг ханган ажиллаж байна. (Хүснэгт 16)

Хүснэгт 16. Шалгалт тохируулгын анализатор, симуляторын жагсаалт 2024 он

Нэр	Загвар	Тоо ширхэг
Өвчтөний хяналтын мониторийн симулятор	ProSim 8	3
Нярайн дулаацуулах ширээ, нярайн инкубаторын анализатор	INCUTM INCUII	2 4
Цахилгаан мэс заслын аппаратын анализатор	QA-ES II QA-ES III	2 4
Шингэний шахуургын анализатор	IDA-5/2	2
Дефибрилляторын анализатор	IMPULSE 7000DP	2
Хийн урсгалын анализатор	VT PLUS HF VT900A	1 4
Хүчилтөрөгчийн анализатор	MAXO2+AE	4
Рентген туяа хэмжигч	TNT 12000WD 12000D 12000 DOSEMATE RaySafe X2	1 1 1 2
Цахилгааны аюулгүй байдлын анализатор	ESA620	1
Хэт авиан оношилгооны аппаратын фантом	040GSE Pantom	4 2
Нийт		40

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн салбарт 2024 онд нийлүүлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл

Техникийн комисст албан хүсэлт ирүүлсэн ханган нийлүүлэх байгууллагын захиалагчтай хийсэн гэрээнд тусгагдсан 420 (давхардсан тоогоор) нэр төрлийн 11302 эмнэлгийн тоног төхөөрөмж, мэс заслын багажийн, техникийн үзүүлэлтийг хангаж буй эсэх дагалдах хэрэгслийн тоо ширхэг, бүрэн байгаа эсэхийг комиссын гишүүд хянаж, урьдчилсан дүгнэлт гарган ажилладаг.

Уг техникийн комиссын урьдчилсан дүгнэлтэд үндэслэн эрүүл мэндийн салбарт 2024 онд нийлүүлэгдсэн өндөр өртөгтэй (200 сая дээш үнэтэй) эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг нэгдүгээр хүснэгтэд, олон тоогоор (10 дээш) нийлүүлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг хоёрдугаар хүснэгтэд харуулав. (Хүснэгт 17)

**Хүснэгт 17. 2024 онд нийлүүлэгдсэн өндөр өртөгтэй
эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл**

Нэр төрөл	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг
Оношилгооны тоног төхөөрөмж	Компьютер томографийн аппарат	4
	Хэт авиан оношилгооны аппарат /суурин/	6
Лабораторийн тоног төхөөрөмж	Flexmap 3d system	1
	Иммуногистохимийн бүрэн автомат будагч аппарат	1
Мэс заслын тоног төхөөрөмж	Revo-I удирдлагын консол Revo-Sim сургалтын симулятор (программ хангамж)	1
	Элэг цөс нойр булчирхайн мэс заслын 3D/4K флюоресценцийн дүрслэл дурангийн мэс заслын цамхаг	1
	Хэвлийн хөндийн ходоод бүдүүн гэдэсний 4K флюоресценцийн дүрслэл дурангийн мэс заслын цамхаг	1
НИЙТ		15

**Хүснэгт 18. 2024 онд нийлүүлэгдсэн олон тоогоор
нийлүүлэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл**

Нэр төрөл	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг
Оношилгооны тоног төхөөрөмж	Рентген аппарат /зөөврийн/	15
	Хэт авиан оношилгооны аппарат /зөөврийн/	65
	Өвчтөний хяналтын монитор	64
	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	33
	Даралтын аппарат	1344
	Халуун хэмжигч	1334
	Тарианы автомат шахуурга	50
Лабораторийн тоног төхөөрөмж	Биохимийн бүрэн автомат анализатор	20
	PCR мастермиксийн кабинет	11
	Шээсний анализатор	19
	Лабораторийн хөргөгч	13
	Автомат пипетка	183
	Автомат пипеткын суурь	24
	Дээж тээвэрлэх сав	15
	Билиметр	33
	Холигч/Вортек	12
	Хөлдөөгч, -25°C	11
	Сахар хэмжигч	1334
Эмчилгээний тоног төхөөрөмж	Сөрөг даралтат аппарат	10
Ариутгалын тоног төхөөрөмж	Автоклав	13
Физик эмчилгээний тоног төхөөрөмж	УВЧ	17
	Гар массажны аппаратын иж бүрдэл	1334
Ор	Өвчтөний ор	11
Эмнэлгийн тавилга	Лабораторийн дугуй сандал	24
Анхны тусламж	Анхны тусламжийн цүнх	1334
НИЙТ		7323



Авлигатай
тэмцэх газар



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛАЛТ

1. Албаны бүрэн эрхийн хүрээнд олж авсан мэдээллээ хувьдаа ашиглах.

2. Албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа хэлбэрээр төлбөр, нэмэлт хураамж авах.

3. Албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэйгөө хамаарал бүхий этгээдийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, түүнд оролцох.

4. Албан үүрэгтээ хамааралгүй тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалаа ашиглах, байгууллага, аж ахуйн нэгжийг төлөөлөх.

5. Өөрийн болон өөрт хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргахад нөлөөлөх.

6. Албан үүргээ гүйцэтгэсний төлөө шууд болон шууд бус хэлбэрээр бэлэг авах.

7. Нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс хандив авах, хүсэлт гаргах. Дээрх тохиолдолд өөрийн удирдлагаас зөвшөөрөл авах хэрэгтэй.

8. Хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд давхар ажил эрхлэх.

9. Албан тушаалтан хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллах

10. Нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсэж болох үйл ажиллагаанд оролцох.

11. Оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгө, хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулах.

12. Албан үүрэг болон өөртэйгөө шууд, шууд бусаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг төлөөлөх.

13. Улс төрд нөлөө бүхий этгээдэд төрөөс санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, арилжааны шинжтэй төсөл, хөтөлбөр, төрөөс олгох хөнгөлөлт, баталгаа, хандив, зээл хүртэгч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч байж болохгүй.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиас...

Авлигын эсрэг

...НЭГДЭЭ

Үгүй гэж хэлээд өөрчилье! 110



Авлигатай
тэмцэх газар



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАН ТАНД БЭЛЭГ, ҮЙЛЧИЛГЭЭ, АШИГТАЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ САНАЛ БОЛГОСОН ТОХИОЛДОЛД:



САНАЛААС ТАТГАЛЗАХ;



САНАЛ ТАВЬСАН ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ;



ЭРГҮҮЛЭН ӨГӨХ БОЛОМЖГҮЙ БОЛ БЭЛГИЙГ ХАДГАЛАХ БА ЭНЭ
ТУХАЙ ӨӨРИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН, ЭРХ БҮХИЙ
БАЙГУУЛЛАГАД НЭН ДАРУЙ МЭДЭГДЭХ;



БОЛОМЖТОЙ БОЛ ТУХАЙН ҮЙЛ ЯВДЛЫН ГЭРЧИЙГ ТЭМДЭГЛЭХ;



БОЛСОН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭГДЛЭЭ БОЛОМЖИТ
ХУГАЦААНЫ ДОТОР ӨӨРИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН, ЭРХ
БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД БИЧГЭЭР ХҮРГҮҮЛЭХ;



ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХЭЭР ЗӨРЧИЛ ИЛЭРСЭН ТОХИОЛДОЛД ЭРХ
БҮХИЙ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД МЭДЭГДЭХ.

*Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг
сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйл.*

Авлигын эсрэг

...НЭГДЭГЭ

Үгүй гэж хэлээд өөрчилъе! 110